



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 654

Улаанбаатар хот

### “Капекс Капитал” ХХК-ийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 174 дүгээр тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”-ын 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Капекс Капитал” ХХК-ийг виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих, виртуал хөрөнгийг шилжүүлэх, виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах үйл ажиллагааг эрхлэх виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэсүгэй.

2.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Капекс Капитал” ХХК (Ч.Баттөр)-д үүрэг болгосугай:

1/Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, харилцагчийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн ажиллах;

2/Бүртгэлтэй үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан зохих өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН